



# МОНГОЛ УЛС

## ӨСӨЛТИЙН ЭХ ҮҮСВЭРҮҮД

Дэлхийн банкны тухайн улсын эдийн засгийн  
талаарх танилцуулга, 2007

Илтгэгч

Сударшан Гоопту

Дэлхийн банкны Тэргүүлэх эдийн засагч

2007 оны 10 дугаар сар

# Энэхүү эдийн засгийн тайланд юу ӨГҮҮЛЭХ ВЭ...

- Энэхүү тайланг гаргахад хамгийн сүүлийн үеийн дүн шинжилгээний механизм, түүний дотор шууд болон шууд бус нотлох баримтыг ашиглаж, цаашид тогтвортой бөгөөд өргөн хүрээг хамарсан өсөлт бий болгоход саад тотгор учруулж буй хүндрэлүүдийг тодорхойлох зорилт тавьсан.
- Гол асуултууд:
  - Одоогийн эдийн засгийн энэхүү өндөр өсөлтийг Монгол улсад цааш нь үргэлжлүүлэхийн тулд юу хийх хэрэгтэй вэ?
  - Энэхүү өсөлтийн үр дүнг цаашид Монгол улсын бүх иргэдэд ялангуяа ядуучуудад хүртээх талаар юу хийх ёстой вэ ?




# Хэдэн баримтыг дурдъя...

- Макро эдийн засгийн ерөнхий үзүүлэлтүүдийг харахад Монгол улс нь одоогоор их тааламжтай цаг үед байна.
- Харин гүнзгийрүүлж харвал:
  - ❑ Сүүлийн 10 жилийн хугацаанд ДНБ-ий (бодит) өсөлтийн жинхэнэ эх үүсвэр нь маш төвлөрсөн, зөвхөн уул уурхай болон МАА-д түшиглэсэн үйл ажиллагаанаас хэт хамааралтай байв.
  - ❑ Монгол улс нь хэдхэн төрлийн бүтээгдэхүүний экспортоос (ноолуур, зэс болон алт) хамааралтай байгаа нь цаашид бүтээгдэхүүний үнэ хэлбэлзэх болон байгалийн гамшиг тохиолдоход эдийн засгийг маш эмзэг болгожээ.
  - ❑ Залуу бөгөөд боловсролтой ажиллах хүчин байгаа хэдий ч ажлын байр буй болгох асуудал төдийлөн тогтвортой байж чадсангүй .
  - ❑ Тус улсын хүн ам Улаанбаатар хотод буюу түүний эргэн тойронд улам бүр төвлөрөх болов.




# Сүүлийн хэдэн жил анхан шатны бүтээгдэхүүнээс хамаарах байдал нэмэгдэв

- Эдийн засгийн хоёр үйл ажиллагаа- түүний дотор МАА болон уур уурхай нь 2005 онд бодит ДНБ-ий 40 гаруй хувийг эзэлж байв.
- Гурван бүтээгдэхүүн – үүний дотор зэс, алт болон ноолуур нь 2005 онд Монгол улсын экспортын 67%-ийг эзэлж байв
- Үйлдвэрлэж гаргасан экспортын ихэнх үлэмж хэмжээ нь оёмол, сүлжмэл бүтээгдэхүүн байлаа.





# 100 орныг бүлэглэж судалсны дотор Монгол улс нь хамгийн төрөлжөөгүй эдийн засагтай, 37 дахь орон байв



Source: Database on export diversification (PRMED).  
The higher the index, the lower the degree of diversification



# Уул уурхайн салбар сүүлийн үед өргөжсөн нь сайн, нааштай зүйл байж болох юм...



- 2001-2005 оны хооронд ДНБ-д эзлэх хувийн жин нь бараг хоёр дахин нэмэгдсэн байдалтай харагдаж байгаа боловч энэхүү харьцааг зэрэгцүүлэх үнээр авч үзвэл үр дүн нь төдийлөн дорвитой байж чадахгүй буюу уул уурхайн салбарын ДНБ-д эзлэх хэмжээ сүүлийн 10 жилд дөнгөж 2%-р нэмэгджээ.
- Энэ нь тус салбарт гарсан сүүлийн үеийн өргөжилт нь цэвэр үнээс шалтгаалсан гэдгийг батлан харуулж байна.




# Байгаль орчинд учрах нөлөөг удирдах шаардлагатай

- Монгол улсын бэлчээр болон байгалын баялаг нь (түүний дотор ой болон ан, амьтан) асар их бөгөөд цаашдын эдийн засгийн өсөлтийн чухал эх үүсвэр болох нь дамжиггүй.
- Нөөц баялаг, мал аж ахуй эдийн засагт ноёлж байгаа учраас, байгаль орчны доройтлоос хамгаалах, Монгол улсын газар, бэлчээрийн менежментийг болгоомжтой хийх нь юу юунаас чухал.
- Ингэснээр энэхүү хомс эх үүсвэрийн бүтээмжийг өндөр байлгаж, тус улсын “жинхэнэ баялгийг” (устаж дуусах, сэргээгдэхгүй нөөцийг үнэлснээр) барагдуулахгүй байх боломж олгоно.



# Уул уурхайн салбараас бусад салбарт нэг ажилчны үйлдвэрлэх нэмүү өртөг Монгол улсад бага байна



Source: Staff estimates based on data from Mongolian Statistical Yearbook (2004) and Government of Mongolia



# Өнөөдөр юу хийснээс ирээдүй шалтгаална

---

Засгийн газар сүүлийн үед зөв чиглэлд чиглэсэн зарим арга хэмжээ авав:

- Татварын хуулийг шинэчилж, татвар ногдуулах үйл ажиллагааг бэхжүүлсэн
- Төрийн удирдлага санхүүжилтийн илүү идэвхтэй тогтолцоог буй болгож энэ нь урьд урьдаас илүү нээлттэй, ил тод болсон байна
- Авилгалын эсрэг арга хэмжээний хүрээнд мэдээллийг ил болгох, авилгалын үйлдлийг мөрдөн шалгаж хариуцлага тооцох байгууллагыг бэхжүүлсэн




# Монгол улсын стратегийн байршил нь томоохон боломж олгож байна

**Бүс нутгийн интеграци: Хятад болон Орос улстай арилжааны харилцаа холбоогоо нэмэгдүүлэх**


- Хөршүүдтэйгээ хийх худалдааны үйл ажиллагааг нэмэгдүүлэхээс олох боломж
- Монгол улсаар дамжин өнгөрөх олон улсын төмөр замын тээвэр жилд 30%-иар нэмэгдэж байгаа

**Хятад, Оростой хийх худалдаа нь Монгол улсын нийт худалдаанд эзлэх хувь (%)**



Source: Mongolia Statistical Yearbook

## Орос, Хятадын худалдаа




- Монгол улсын гадаад худалдааны 60 орчим хувь нь Орос болон Хятад улсад ногдож байна



## Дотоод интеграцлал дэмжлэг болох нь

- Асар том газар нутагтай боловч хүн амын нягтшил багатай улс дотроо илүү сайн холбогдох боломж байна
- Уул уурхайтай холбоотой дэд бүтцийг ашиглан тухайн уул уурхайд түшиглэсэн хот суурин газар болон түүнтэй хил залгаа орон нутгийг ханд тогтвортой дэд бүтцийн үйлчилгээ үзүүлэх

Улаанбаатар болон аймгийн төвүүдийн хэмжээ ба өсөлт  
(Size of circle represents current population)



Source of raw data: Mongolia Statistical Yearbook

Гэвч сүүлийн үеийн эдийн засгийн өсөлтөөс буй болсон боломж нь дэд бүтцийн үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой бэрхшээлээс шалтгаалан хязгаарлагдмал байна



# Хурдацтай явагдаж буй хотжилтыг удирдах, төлөвлөх шаардлага байна

## Монгол улсын хот суурин газрын хүн ам



Source: United Nations

2030 он гэхэд Монгол улсын 67% нь хот суурин газарт төвлөрсөн байна




## Дэд бүтцийн үйлчилгээг эрх тэгш бус хүргэж байгаа болон үнийн доошоо буурсан дэглэм үйлчилж байна


- Ядуу бус хүн ам нь дэд бүтцийн үйлчилгээг илүү сайн авч байна
- Ядуучуудын зөвхөн 30% нь бүх 3 төрлийн үйлчилгээг авч чадаж байна (усны сайжруулсан эх үүсвэр, бохирын систем болон цахилгаан эрчим хүч)

Ядуу бус хүмүүсийн авч буй дэд бүтцийн үнэ нь зардлаасаа доогуур байна

Ядуурлын байдлаасаа шалтгаалан дэд бүтцийн үйлчилгээ авч байгаа нь



Source: Mongolia Household Income and Expenditure Survey Report




Source: World Bank, Mongolia Infrastructure Strategy Report 2007.

- Байр, орон сууцанд амьдарч байгаа иргэдийн хэрэглэж буй түлшний үнэ нь зардлаасаа бага байна
- Гэр хорооллын оршин суугчид хэрэглэж байгаа нүүрснийхээ үнийг бүрэн төлж байна



# Том байснаас хэмнэх явдал байхгүй байна

Монгол улс: Орлогын нягтшил (2005)




Source: World Bank, Mongolia Infrastructure Strategy Report, 2007

- Том байснаас хэмнэх бололцоо бага байгаагаас (усан хангамжтай холбогдуулан) жижиг хотуудын хувьд нэг хүнд ногдох зардал өндөр байна

- Дэлхий нийтийн дундажтай харьцуулахад нэг хавтгай дөрвөлжин км талбайд ногдох орлогын нягтшил бага байна
- Сүлжээг өргөтгөх эдийг засгийн боломжийг бууруулж байна

Монгол улс: Усны хангамжийн харьцангуй зардал, 2005 (250,000 оршин суугчтай хотуудтай харьцуулснаар )



Source: World Bank, Mongolia Infrastructure Strategy Report, 2007.



## Бизнесийн орчин Зэрэглэл буурч байна

Хэр хялбар байна вэ...	2006 оны байдлаар	2005 оны байдлаар	Зэрэглэлд гарсан өөрчлөлт
Бизнес хийхэд	45	41	-4
Бизнес эхлүүлэхэд	55	54	-1
Тусгай зөвшөөрөл авахад	34	35	+1
Ажилтан хөлслөн авахад	61	57	-4
Өмч хөрөнгө бүртгүүлэхэд	17	17	0
Зээл авахад	65	59	-6
Хөрөнгө оруулагчдыг хамгаалахад	19	18	-1
Татвар төлөхөд	56	53	-3
Хил давуулан наймаалахад	162	161	-1
Гэрээг албадан хэрэгжүүлэхэд	41	40	-1
Бизнесээ хаахад	115	113	-2


Source: Doing Business, 2007



## Бизнесийн орчин

### Монголын бизнес эрхлэгчид юу гэж хэлсэн байна вэ

(Дараах бэрхшээлүүдийг томоохон буюу ноцтой бэрхшээл гэж үзсэн АА-н нэгжийн эзлэх хувийн жин)



- ▶ Монгол улсад бизнесийн үйл ажиллагаа явуулахад саад болж буй гэж хамгийн олон нэрлэгдсэн бэрхшээл нь авилгал байв
- ▶ ...харьцуулж болохуйц хөрөнгө оруулалтын орчны талаарх судалгаа бүхий 62 оронтой харьцуулахад авилгал бизнес хийхэд хамгийн том буюу ноцтой бэрхшээл учруулж байгаа гэж үзсэн АА-н нэгжийн тоо бусдаас илүү байлаа



## Бизнесийн орчин – Наад захын онош...

### Яагаад авилгал, төр-бизнесийн харилцааны хариуцлагагүй, ил тод бус байдал гол бэрхшээл болов?

**Хүснэгт 1 : Авилгал бизнесийн бүх салбарт ноёлж байна**

Авилгалыг бэрхшээл гэж буй үзэж буй ААН-ийн %	Эрчим хүчний сүлжээнд холбогдоход хаууль өгсөн ААН-үүд %	26.0
Төрийн худалдан авах гэрээг авахад төлөх шагнал (гэрээний %)	Утас тавиулахад хахууль өгсөн ААН-үүд %	23.0
Бизнес хийхэд улс төрийн хэлхээ холбоо хэрэгтэй гэж үзэж буй ААН %	Усны сүлжээнд холбогдоход хахууль өгсөн ААН-үүд %	15.0
Бүртгүүлэхэд албан бус төлбөр төлсөн тохиолдол %	Гаальд хахууль өгсөн экспортлогчид	25.0
Тусгай зөвшөөрөл авахад албан бус төлбөр төлсөн тохиолдолд %	Гаальд хахууль өгсөн импортлогчид	22.6

Эх үүсвэр: Монголын Бүтээмж, Хөрөнгө оруулалтын орчны судалгаа, 2004.

- ▶ **Үүнээс харахад авилгал, төр-бизнесийн харилцааны хариуцлага тооцох, ил тод байдал тодорхойгүй байгаа нь бизнесийн үйл ажиллагааны бүхий л салбарт ноёлж байна**



# Монголын ААН-үүд “ШБОС” гаргадаг уу?

- Үйлдвэрлэлийн тогтолцоог төрөлжүүлэх нь эдийн засгийн өртөг зардлын тогтолцоог “илрүүлэхийг” шаарддаг
  - ААН-үүд шинэ технологийг орон нутгийн түвшинд тохируулах, ашигтай байж чадахуйц бага зардлаар ямар бүтээгдэхүүн үйлдвэрлэх вэ гэдгийг “нээх” шаардлагатай
- Монголын үйлдвэрлэлийн бааз явцуу байгаа нь ААН-үүд шинэ бүтээгдэхүүн экспортлохоор оролддоггүйдээ биш; 2002-06 онуудад
  - 4 оронтой тоогоор хэмжигдэх экспортын 30% нь шинэ бүтээгдэхүүн байсан
  - Үүнээс, 70 - 80% нь шинээр үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн байв
  - Гэвч шинэ бүтээгдэхүүний тал хувийг дараа жил нь экспортод гаргаагүй байна, үүний ихэнх хувийг шинээр үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн эзэлж байв



# Ямар “Ороосон хүндрэлүүд” тулгарч байна вэ?

- *Дэд бүтцийн бөглөө* үүнээс болж тээврийн зардал өндөр, бэлтгэл ажил ээдрээтэй, тээвэрлэх хугацаа урт байна.
- *Тогтворгүй татварын орчин*, ялангуяа уул уурхайн салбарт, мөн гааль, худалдааны олон дүрэм, журам зэргээс шалтгаалан Монгол улсад бизнес хийх зардал өндөр болж байна.



# Ямар ороосон хүндрэлүүд тулгарч байна вэ? (үргэлж.)

- *Илүү сайн уялдуулах, зохицуулах шаардлага.*
  - *Хууль тогтоомж*
  - *Худалдаа ба бэлтгэл ажил*
  - *Салбарын стратеги ба хэрэгжүүлэх төлөвлөгөө*
  - *Нөөц баялгийн хэрэглээ ба байгаль орчны доройтол.*
- *Авлига нэмэгдэж байгаа ба гэрээг хангалттай албадан хэрэгжүүлж чадахгүй байх*
- *Хөрөнгийн өндөр өртөг*



# “Яаж...?”

- “Түргэн үр дүн” гаргахын тулд тогтвортой өсөлтөд саад болж буй бэрхшээлийг дараахь аргаар шийднэ:
  - Хөрөнгө оруулалтын орчны шинэтгэл,
  - Олон нийтэд үр ашиг нь хүртэх, үр бүтээлтэй төрийн хөрөнгө оруулалтын төсөл,
  - Ажиллах хүчнийг дутуу ашиглаж, мэргэжлээр нь ажиллуулж чадахгүй байгааг шийдэх.
- Энэ нь уул уурхайн салбарыг дэмжээд зогсохгүй бусад экспортын салбарыг төрөлжүүлэхэд ч тус нэмэр болно
  - Шинэ зах зээлд нэвтрэх (дотооддоо болон гадаадад), ажлын байр шинээр буй болгох.
  - ААН-үүд шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ буй болгох урамшилтай болгох
  - Чанар үр ашгийг дээшлүүлэх.




## Жишээ: Ноолуурын салбарт илүү уялдаа холбоо хэрэгтэй байна

- Нэг зэрэг, томоохон хөрөнгө оруулалт шаардах дараахь үйлчилгээ ААН-д шаардлагатай:
  - Одоогийн бүтээгдэхүүний хэмжээг нэмэгдүүлэх;
  - Чанар сайжруулах;
  - Экспортийн барааны тоог нэмэгдүүлэх;
- Хятад руу бохир ноолуур их хэмжээгээр гарч байгаа нь ноолуурын энэхүү чухал салбарт Засгийн газар зохицуулах үүргээ гүйцэтгэж чадахгүй байгаагийн дохио болно
  - Малчдад ноолуурын чанараа сайжруулахын тулд, санхүү, мэдээлэл, дэд бүтэц хэрэгтэй байна
  - Боловсруулагчдад малчидтай стратегийн холбоо тогтоох урамшуулал байхгүй байна
- Үүний зарим үр дагавар:
  - Чанартай ноолуур дутагдаж байна
    - Боловсруулагчид хүчин чадалдаа хүрч ажиллаж чадахгүй байна
    - Ноолуурын тансаг бүтээгдэхүүн үйлдвэрлэгчид хөрөнгө оруулахад саад болж байна
  - Байгаль орчны доройтол



# Дэд бүтэц: Монгол Улсын хөрөнгө оруулалтын хэрэгцээ дараагийн 10 жилд: Нэн тэргүүний зорилтоо зөв тодорхойлох



Эх үүсвэр Монгол Улсын Дэд бүтцийн стратеги тайлан

- Засгийн газраас төлөвлөж буй дэд бүтцийн хөрөнгө оруулалт нь давж дийлшгүй, тогтворгүй хэмжээнд буюу ДНБ-ний 48%-д хүрэхээр байна.
- Дэлхийн банкны дэд бүтцийн стратегийн тайланд зааснаас харахад уг хөрөнгө оруулалтыг багасгахад ч урьд хожид байгаагүй хэмжээ буюу ДНБ-ний 22% байхаар байна
- Санхүүгийн бэрхшээлээс болоод амаргүй шийдвэр гаргах, хөрөнгө оруулалтын хувилбараа нэн тэргүүний зорилтоор нь ялгах хэрэгтэй болно
- Санхүүгийн хувьд зохиомол шийдэл гаргах нь төслийн чанарыг сайжруулж чадахгүй (татвар төлөгчид, хэрэглэгчид ачааг нь үүрэх болно)



# Гэсэн ч шийдэх шаардлагатай эрсдэл байх болно...

- Ашигт малтмалаар баян олон оронд гарсан “Голланд өвчин”.
- Төрийн санхүүгийн бодлого ба мөнгө үрэх популист хөтөлбөрүүд (төрийн санхүү ба өрийн тогтвортой байдалд заналхийлсэн)
- Хөрөнгө оруулалтын орчин, гадаадын хөрөнгө оруулагчдын сонирхлыг татах чадварт нөлөөлөх дотоод бодлого, түүний дотор татварын бодлого
- Аж ахуйн үйл ажиллагааны өртгийг нэмэгдүүлэхэд хүрч буй авилгалын талаарх төсөөлөл, сул засаглал
- Байгаль орчны эрсдэл.



# Энэ нь дараахь арга

## ХЭМЖЭЭНҮҮДИЙГ шаардана...

- Төрийн санхүү, өрийн тогтвортой байдлыг харгалзан үзсэнээр макроэдийн засгийн тогтвортой байдлыг хангахын тулд гэнэтийн ашгийг зөв удирдах
- Үр бүтээлтэй хөрөнгө оруулалт, олон нийтийг хамарсан өсөлт буй болгохын тулд гэнэтийн ашгаар нухацтай судалж хөрөнгө оруулалт хийх
- Төсвийн гадуурх механизмаар бус төсвөөр дамжуулан төрийн санхүүгийн гэнэтийн бодлогыг албан ёсны бүтцэд оруулах
- Авлигалын эсрэг хууль болон Олборлох салбарын ил тод байдлын санаачлагыг нэн тэргүүнд хэрэгжүүлэх. Үүний хүрээнд Засгийн газар уул уурхайн салбараас олсон орлогын талаарх тоо баримтаа цуглуулах, нэгтгэх, хэвлэх үүрэг хүлээх болно



# ТҮҮНЧЛЭН...

- Бэлчээрийн болон мал аж ахуйн удирдлагыг сайжруулах. Эрсдэлээс хамгаалах арга хэмжээний хүрээнд газар, ус, мал хоорондын маш чухал шүтэлцээг харгалзан үзэх
- Уул уурхайн үйл ажиллагааны байгаль орчны үр дагавар болон Улаанбаатар хот зэрэг хүн ам нягтаршилтай суурин газрын агаарын бохирдлын асуудлыг өргөн фронтоор шийдэх.



# БОДЛОГЫН ЗӨВЛӨМЖ

## Дэд бүтцийн бөглөрлийн талаар

### Шинэчлэлийн ерөнхий хандлага

- Төрийн хөрөнгөөр хийх дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг нэн тэргүүний зорилгоор нь ялгах
- Өртөг зардал, төрийн санхүүгийн тогтвортой байдлыг харгалзан үзсэнээр салбарын хөрөнгө оруулалтын стратегийг албан ёсны болгох
- Дэд бүтцийг барьж байгуулах болон үйлчилгээ үзүүлэх талаар төр, хувийн хэвшл хамтын ажиллагааг зохицуулах журам гаргах

### Одоо хэрэгжүүлвэл зохих бодлогын арга хэмжээ

- **Үнэ**
  - Засвар үйлчилгээ, өргөтгөлийн зардал гаргахын тулд үнийг үйлчилгээний зардалтай нийцүүлэх
  - Ядуучуудыг хамгаалах зорилгоор ил тод, зөв тодорхойлсон зорилтот хүн амд чиглэсэн татаас хэрэгжүүлэх
- **Үр ашиг ба засаглал**
  - Үнэ нэмэгдэхтэй уялдуулан үр ашгийг сайжруулах
  - Бодлого, эрх зүйн шинэчлэл хийж засаглалыг сайжруулснаар Монгол улс дотроо болон гаднаас хөрөнгө оруулалтыг татах
- **Илүү сайн төлөвлөх**
  - Эдийн засгийн үр өгөөжийг дээшлүүлэн, ядуурлыг бууруулахын тулд нөөц баялгийг илүү зөв хуваарилах
  - Төслүүдийг нэн тэргүүнд хэрэгтэйгээр нь тодорхойлж, хувийн хэвшил, иргэний нийгмийн үүрэг, ролийг нэмэгдүүлэх



# Бодлогын зөвлөмж

## Татварын тогтворгүй дэглэмийн талаар

### Шинэчлэлийн ерөнхий хандлага

- Уул уурхайн компаниудын хувьд ногдуулах татварын багц болон тэдэнтэй байгуулах Хөрөнгө оруулалтын гэрээг нухацтай боловсруулах
- Татвар ногдуулах ажиллагааг сайжруулах
- Шалгалтын дэглэмийг сайжруулж, аудит шалгалтын хүрээнд ААН болон хэрэглэгчдийн эрхийн талаарх мэдээлэл тараах
- Гаалийн үйл ажиллагааг сайжруулах

### Одоо хэрэгжүүлвэл зохих бодлогын арга хэмжээ

- Уул уурхайн нөөц ашигласны төлбөр, уул уурхайн төсөлд Төрийн хувь эзэмшлийг эргэн харж, дахин үнэлэх
- Хэмнэлтийг үр ашигтай удирдах: Улс хөгжүүлэх сангийн удирдлага, менежментийн талаарх төрийн санхүүгийн тодорхой дүрэм, журам батлах



# Бодлогын зөвлөмж

## Уялдан зохицуулах явдлыг сайжруулах

### Шинэчлэлийн ерөнхий хандлага

- Цаашид өсөх асуудал нь худалдаанаас шалтгаалж буй ААН-үүдэд тулгарч буй тээврийн зардал, ээдрээтэй бэлтгэл ажлыг бууруулах (уул уурхайн болон бусад салбарт).
- Монгол улсад ажиглагдаж буй нүүн шилжих явдлын эсрэг бус харин түүнийг дагалдсан үйл ажиллагаа явуулах
- Асар өргөн уудам нутагтай байгааг харгалзвал өнөөгийн хурдан өсөж буй эдийн засагт мэдлэг олж авах, түгээх, ашиглах явдалд мэдээлэл холбооны технологи (ICT) маш чухал байна

### Одоо хэрэгжүүлвэл зохих бодлогын арга хэмжээ

- Эдийн засгийн бусад салбарт төв болж чадах, бүх салбаруудад ашиг тустай дэд бүтцэд маш нарийн судалж, хөрөнгө оруулалт хийх
- Монголын арилжааны голлох хөршүүдтэй гааль болон хил худалдааны хууль, тогтоомжоо уялдуулах талаар хэлэлцэж эхлэх
- Ноолуур, махны зах зээлийн эрэлт хэрэгцээ, үнийн талаар малчдад мэдээлэл өгөх
- Ноолуур боловсруулагчдыг доод твшний агентуудтай стратегийн холбоо тогтооход нь туслаж, дэмжих



# Бодлогын зөвлөмж

## Авилгалтай тэмцэх ба гэрээний албадан хэрэгжилтийг сайжруулах

Одоо хэрэгжүүлвэл зохих бодлогын арга хэмжээ

### Шинэчлэлийн ерөнхий хандлага

- Мэдээллийн эрх чөлөөний хуулийг хэрэгжүүлж, төрийн мэдээллээс олж авахад хялбар болгох
- Төв болон орон нутгийн хэмжээнд төрийн санхүүгийн бодлогын ил тод байдлыг хангах
- Тус улсын засаглал, авилгалын эсрэг болон төрийн зардлын талаарх судалгааны үр дүнг тогтмол хэвлэж байх
- Шинэчлэлийг хэрэгжүүлэх явцын үр дүнг иргэдэд хянах бололцоо олгох
- Тусгайлсан сургалт явуулж, төрийн албан хаагчдын мэргэжлийн ур чадвар болон ёс зүйг дээшлүүлэх

- ОСИТБС-ыг хэрэгжүүлэх: Олон салбарынхныг хамарсан хороо байгуулах. Тайлангийн маягтыг харилцан тохирч гаргах. Уул уурхайн салбартай холбогдон төрийн авч буй орлого, зарлагын талаар ОСИТБС-ын тайланг гаргаж, тараах
- Хөрөнгө, орлогын мэдүүлгийн хууль хэрэгжүүлэх. Төрийн өндөр албан тушаалын ажилтан, сонгуульд нэр дэвшигчид, төрийн албаны ажилтнууд болон ИХ-ын гишүүд орлогоо мэдүүлдэг болох
- Худалдан авах үйл ажиллагаа болон босго шалгуурыг эргэн харах. Төрийн өмч хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авахад гарааны тэгш эрх олгох



# Бодлогын зөвлөмж

## Хөрөнгийн өндөр өртгийн талаар

Шинэчлэлийн ерөнхий хандлага

Одоо хэрэгжүүлвэл зохих бодлогын арга хэмжээ

- Санхүүгийн зуучлалыг сайжруулах
- Банк хоорондын зах зээл буй болгох
- Урсгал зардал болон хадгаламжийн төлөө хэрээс хэтэрсэн өрсөлдөөнийг багасгахын тулд банкны салбарыг цомхтгох
- Хадгаламжийн даатгал, түүний хувилбаруудыг судалж үзэж
- ХЗХ, ТББ болон санхүүгийн компаниудыг зохицуулах хууль тогтоомжоор хадгаламж хуримтлуулах ажиллагааг илүү сайн хянаж, бичил болон дунд хэмжээний санхүүгийн зуучлалын чанарыг сайжруулах
- Зээлийн мэдээлэл болон үнэт цаасны эрхийн бүртгэлийг сайжруулах
- Санхүүгийн болон санхүүгийн бус аж ахуйн нэгж нэг этгээдийн өмчлөлд байх явдлыг хориглох буюу хатуу хяналтад байлгах



Эдийн засгийн санамж бичгийн  
цахим хувилбар:

<http://www.worldbank.org/mn/mnpublications>

